| **2024 I** | **17,435** | **4,930** | **2,486** | **50.4%** | **28.3%** |
| II | 53,198 | 13,964 | 6,521 | 46.7% | 26.2% |
| III | 73,959 | 18,564 | 8,976 | 48.4% | 25.1% |
| IV | 112,390 | 33,485 | 16,763 | 50.1% | 29.8% |
| **2025 I** | **22,952** | **2,842** | **1,478** | **52.0%** | **12.4%** |

Мэдээллийн эх үүсвэр: Хөдөлмөр, халамж үйлчилгээний ерөнхий газар

Хөдөлмөрийн зах зээлийн эрэлтийг эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангиллаар авч үзвэл, 2025 оны I улиралд ирсэн ажлын байрны захиалгын 5.1 мянга нь уул уурхай, олборлолт (22.1 хувь), 4.2 мянга нь барилга (18.1 хувь), 3.5 мянга нь боловсруулах үйлдвэрлэл (15.4 хувь), 2.5 мянга нь цахилгаан, хий, уур, агааржуулалт (10.9 хувь)-ын салбараас ирсэн байна.

## Хүснэгт 8. Ажлын байрны захиалга, ажилд зуучлагдсан иргэд, 2025 оны I улирал

| Үзүүлэлт | Ажлын байрны захиалга | Эзлэх хувь | Ажилд зуучлагдсан иргэн | Эзлэх хувь | Эрэлт хангасан хувь |
|---|---|---|---|---|---|
| Бүгд | 22,952 | 100.00% | 2,842 | 100.00% | 12.38% |
| ХАА, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур | 1,631 | 7.11% | 448 | 15.76% | 27.47% |
| Уул уурхай, олборлолт | 5,060 | 22.05% | 205 | 7.21% | 4.05% |
| Боловсруулах үйлдвэрлэл | 3,534 | 15.40% | 330 | 11.61% | 9.34% |
| Цахилгаан, хий, уур, агааржуулалт | 2506 | 10.92% | 21 | 0.74% | 0.84% |
| Ус хангамж, бохир ус зайлуулах систем, хог хаягдал | 728 | 3.17% | 261 | 9.18% | 35.85% |
| Барилга | 4,152 | 18.09% | 130 | 4.57% | 3.13% |
| Бөөний болон жижиглэн худалдаа | 766 | 3.34% | 164 | 5.77% | 21.41% |
| Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа | 707 | 3.08% | 34 | 1.20% | 4.81% |
| Зочид буудал, байр, нийтийн хоолны үйлчилгээ | 450 | 1.96% | 36 | 1.27% | 8.00% |
| Мэдээлэл, холбоо | 52 | 0.23% | 11 | 0.39% | 21.15% |
| Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа | 55 | 0.24% | 22 | 0.77% | 40.00% |
| Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа | 123 | 0.54% | 0 | 0.00% | 0.00% |
| Мэргэжлийн ШУ болон техникийн үйл ажиллагаа | 95 | 0.41% | 52 | 1.83% | 54.74% |
| Удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа | 635 | 2.77% | 139 | 4.89% | 21.89% |
| Төрийн удирдлага ба батлан хамгаалах | 1,211 | 5.28% | 606 | 21.32% | 50.04% |
| Боловсрол | 501 | 2.18% | 206 | 7.25% | 41.12% |
| Хүний эрүүл мэнд ба нийгмийн халамжийн үйл ажиллагаа | 399 | 1.74% | 88 | 3.10% | 22.06% |
| Урлаг, үзвэр, тоглоом наадам | 86 | 0.37% | 15 | 0.53% | 17.44% |
| Үйлчилгээний бусад үйл ажиллагаа | 246 | 1.07% | 71 | 2.50% | 28.86% |
| Хүн хөлслөн ажиллуулдаг өрхийн үйл ажиллагаа | 10 | 0.04% | 1 | 0.04% | 10.00% |
| ОУ-ын байгууллага, суурин төлөөлөгчийн үйл ажиллагаа | 5 | 0.02% | 2 | 0.07% | 40.00% |

Мэдээллийн эх үүсвэр: Хөдөлмөр, халамж үйлчилгээний ерөнхий газар

## Зураг 31. Ажилд зуучлагдсан иргэн, хүйсээр болон насны ангилалаар, 2025 оны I улирал




Мэдээллийн эх үүсвэр: Хөдөлмөр, халамж үйлчилгээний ерөнхий газар

## Зураг 32. Ажлын байрны захиалга, ажил мэргэжлийн ангиллаар, хувиар




Мэдээллийн эх үүсвэр: Хөдөлмөр, халамж үйлчилгээний ерөнхий газар

## Зураг 33. Ажлын байрны захиалга, ажил мэргэжлийн ангиллаар, бүсээр




Мэдээллийн эх үүсвэр: Хөдөлмөр, халамж үйлчилгээний ерөнхий газар

## Зураг 34. Ажлын байрны захиалга, өмчийн хэлбэрээр, бүсээр, хувиар, 2025 оны I улирал




| | Төрийн | | Орон нутгийн | | Хувийн | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | Өмчийн | Хамтарсан | Өмчийн | Өмчийн оролцоотой | Монгол улсын | Гадаадтай хамтарсан | Гадаад улсын |
| Баруун бүс | 722 | - | 23 | - | 1,104 | 1 | 30 |
| Хангайн бүс | 614 | - | 22 | - | 564 | 9 | 231 |
| Төвийн бүс | 460 | 9 | 13 | 1 | 2,639 | 128 | 3,260 |
| Зүүн бүс | 604 | 1 | 14 | - | 1,872 | 50 | 883 |
| Улаанбаатар | 594 | 10 | 30 | 6 | 6,535 | 566 | 1,957 |

Мэдээллийн эх үүсвэр: Хөдөлмөр, халамж үйлчилгээний ерөнхий газар

## Зураг 35. Ажилд зуучлагдсан иргэн, ажил мэргэжлийн ангилалаар, хүйсээр, хувиар




Мэдээллийн эх үүсвэр: Хөдөлмөр, халамж үйлчилгээний ерөнхий газар

## Гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах, гадаадад ажиллах хүч зуучлах

2025 оны I улирлын байдлаар хөдөлмөрийн гэрээгээр гадаадын 103 улсын 9,871 иргэн ажил, хөдөлмөр эрхэлж байна. Хөдөлмөрийн гэрээгээр ажил эрхэлж буй гадаадын иргэдийн 8,451 буюу 85.6 хувь нь эрэгтэйчүүд, 1,420 буюу 14.4 хувь нь эмэгтэйчүүд байна.

Зураг 36. Хөдөлмөрийн гэрээгээр ажил эрхэлж буй гадаадын иргэд, бүсээр




Мэдээллийн эх үүсвэр: www.1212.mn, Үндэсний статистикийн хороо

Мөн хөдөлмөрийн гэрээгээр ажил эрхэлж буй гадаадын иргэдийг иргэншлээр нь авч үзвэл, 5,937 (60.1 хувь) нь Хятад, 627 (6.4 хувь) нь Энэтхэг, 526 (5.3 хувь) нь Вьетнам, 486 (4.9 хувь) нь Филиппин, 326 (3.3 хувь) нь ОХУ, 288 (2.9хувь) нь Өмнөд Солонгос,үлдсэн 1,681 (17.0 хувь) нь бусад улсын иргэн байна.

Зураг 37. Хөдөлмөрийн гэрээгээр ажил эрхэлж буй гадаадын иргэд, хамгийн их 6 улсаар, дунд эзлэх хувиар




Мэдээллийн эх үүсвэр: www.1212.mn, Үндэсний статистикийн хороо

Зураг 38. Хөдөлмөрийн гэрээгээр ажил эрхэлж буй гадаадын иргэд, эдийн засгийн үйл ажиллагааны салбараар, 2025 оны I улирал




Мэдээллийн эх үүсвэр: www.1212.mn, Үндэсний статистикийн хороо

2025 оны I улирлын байдлаар 213 иргэн хөдөлмөрийн гэрээгээр гадаадад ажилд зуучлагдсан бөгөөд өмнөх улирлаас 111 буюу 34.3 хувиар буурсан байна.

Гадаадад ажилд зуучлагдсан иргэдийн 178 (83.6 хувь) нь Өмнөд Солонгос, 35 (16.4 хувь) нь Япон улсад зуучлагдсан. Ажилд зуучлагдсан иргэдийн 175 (82.2 хувь) нь эрэгтэйчүүд, 38 (17.8 хувь) нь эмэгтэйчүүд байна.

Зураг 39. Хөдөлмөрийн гэрээгээр гадаад улсад зуучлагдсан иргэд




Мэдээллийн эх үүсвэр: www.1212.mn, Үндэсний статистикийн хороо

Хөдөлмөрийн гэрээгээр гадаадад зуучлагдсан иргэдийг боловсролын түвшнээр нь авч үзвэл, 61.1 хувь нь бүрэн дунд, 30.5 хувь нь бакалавр, 6.0 хувь нь тусгай мэргэжлийн дунд, 1.2 хувь нь боловсролгүй, 0.6 хувь нь магистр, доктор, 0.6 хувь нь бага боловсролтой байна.

Зураг 40. Хөдөлмөрийн гэрээгээр гадаад улсад зуучлагдсан иргэд, ЭЗҮА-ны салбараар




Мэдээллийн эх үүсвэр: www.1212.mn, Үндэсний статистикийн хороо

# ЦАЛИНГИЙН БҮТЦИЙН СУДЛАГААНД ХИЙСЭН ШИНЖИЛГЭЭНИЙ АЖИЛ-2025 ОН

## Шинжилгээний ажлын танилцуулга

Цалин хөлсний бүтцийн судалгааны шинжилгээний ажил нь улсын хэмжээнд хөдөлмөр эрхлэгчдийн цалин хөлсний бүтцийн судалгааны үр дүнгээр шинэчлэгдэн гарсан мэдээллийг ДНБ, инфляц, зэрэг үзүүлэлтээр харьцуулан, ААНБ-ын үйл ажиллагаа, ажиллагчдын хөдөлмөр эрхлэлт, ажлын байр тэдгээрт зарцуулж буй зардлын мэдээллээр харьцуулж нөлөөлж буй хүчин зүйлсийг тодорхойлох, үндсэн болон нийт цалин, нэмэгдэл, нэмэгдэл хөлс, шагнал урамшуулал зэргийн өөрчлөлт, хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг бусад холбогдох үзүүлэлтүүдтэй уялдуулан дүн шинжилгээ хийдэг.

Энэхүү шинжилгээнд эдийн засгийн хэлбэлзэлтэй үе болох 2019, 2021 болон 2023 оны “Цалин хөлсний бүтцийн судалгаа”-ны тоон өгөгдлийг ашигласан. Цалингийн бүтцийг ажиллагчдын хүйс, боловсрол, аж ахуйн нэгжийн хариуцлагын хэлбэр, эдийн засгийн үйл ажиллагааны салбар, газар зүйн байрлал зэрэг үзүүлэлтээр харьцуулан үр дүнг тооцсон.

Хүснэгт 9. Логарифм цалингийн өөрчлөлтийн регрессийн үнэлгээ

| Харьцуулсан хувьсагчид | 2019 | | 2021 | | 2023 | |
|---|---|---|---|---|---|---|
| | 1. Үнэлэгдсэн коэффициент | Стандарт алдаа | 2. Үнэлэгдсэн коэффициент | Стандарт алдаа | 3.Үнэлэгдсэн коэффициент | Стандарт алдаа |
| **Техникийн боловсрол** | 0.143 | 0.008 | 0.131 | 0.011 | 0.093 | 0.009 |
| **Дээд боловсрол** | 0.439 | 0.007 | 0.357 | 0.008 | 0.280 | 0.008 |
| **Туршлага** | 0.019 | 0.001 | 0.012 | 0.001 | 0.002 | 0.000 |
| **Туршлагын квадрат** | 0.000 | 0.000 | 0.000 | 0.000 | 0.000 | 0.000 |
| **Эрэгтэй** | 0.111 | 0.006 | 0.106 | 0.007 | 0.122 | 0.006 |
| **Төрийн өмч** | 0.078 | 0.012 | 0.095 | 0.018 | 0.037 | 0.015 |
| **Хувийн** | 0.003 | 0.012 | 0.005 | 0.018 | 0.036 | 0.014 |
| **Аж үйлдвэр** | 0.101 | 0.007 | 0.148 | 0.008 | 0.070 | 0.007 |
| **ХАА** | -0.027 | 0.027 | -0.100 | 0.031 | -0.011 | 0.011 |
| **Хангай** | -0.246 | 0.010 | -0.158 | 0.011 | -0.231 | 0.012 |
| **Төв** | -0.120 | 0.009 | -0.079 | 0.011 | -0.043 | 0.012 |
| **Зүүн** | -0.196 | 0.014 | -0.089 | 0.015 | -0.120 | 0.020 |
| **Баруун** | -0.251 | 0.011 | -0.195 | 0.012 | -0.199 | 0.013 |
| **Тогтмол** | 6.268 | 0.014 | 6.382 | 0.020 | 6.825 | 0.016 |
| **Ажиглалтын тоо** | 37,977 | | 23,087 | | 29,053 | |
| **R2** | 0.15 | | 0.13 | | 0.08 | |

Энэ загварын хувьд суурь харьцуулалтын бүлэг нь үйл ажиллагаа эрхэлж байгаа байршлын хувьд Улаанбаатар хотын буюу орон нутгийн өмчлөлтэй ААНБ-уудад хөдөлмөр эрхэлдэг, бүрэн дунд болон түүнээс доош боловсролтой, үйлчилгээний салбарын, ажлын туршлагагүй, эмэгтэй ажиллагчид байна. Тус бүлгийн ажиллагчдын цалинг суурь цалин гэж үзнэ.

Техникийн, эсвэл дээд боловсролтой ажиллагчдын цалинтай харьцуулахад боловсролын өгөөж: Дээд боловсролтой ажиллагчдын цалин 2019 онд бусад ажиллагчдынхаас 43.9 хувиар өндөр, техникийн боловсролтой ажиллагчдын цалин 14 хувиар өндөр байсан. Харин 2021, 2023 онуудад боловсролын өгөөж буурах хандлагатай байсан бөгөөд 2023 онд дээд боловсролын өгөөж 1.6 хувиар, техникийн боловсролын өгөөж 5 хувиар буурсан.

Эрэгтэй ажиллагчдын цалинтай харьцуулахад: Эрэгтэй ажиллагчдын цалин эмэгтэйчүүдийнхээс өндөр байна. Тухайлбал, 2019 онд цалингийн ялгаа нь 11.1 хувь байсан бол 2023 онд 12.2 буюу 1.1 хувиар илүү цалинтай байсан.

Үйлчилгээний салбарын ажиллагчдын цалинтай харьцуулахад бусад эдийн засгийн салбар: Хөдөө аж ахуйн салбарын ажиллагчдын цалин үйлчилгээний салбарт ажилдаг ажиллагчдын цалинтай харьцуулахад бага харин аж үйлдвэрийн салбарын ажиллагчдын цалин их байна. Тухайлбал: 2019 онд хөдөө аж ахуйн салбарын цалин 2.7 хувиар бага байсан бол 2021 онд 10 хувьд хүрч багассан бөгөөд 2023 онд энэ ялгаа 1.1 хувь болсон. Харин аж үйлдвэрийн салбарын ажиллагчдын цалин үйлчилгээний салбарын ажиллагчдын цалингаас 2019 онд 10 хувиар өндөр байсан бол 2021 онд 14.8 хувь буюу 4.8 хувиар өссөн бөгөөд 2023 онд буурч 7 хувьтай болсон буюу эхний онтой харьцуулахад багаар өссөн байна.

Улаанбаатар хотын ажиллагчдын цалинтай харьцуулахад бусад бүс: Орон нутгийн байгууллагуудын ажиллагчдын цалинг Улаанбаатар хотын ААНБ-д хөдөлмөр эрхэлдэг ажиллагчдын цалинтай харьцуулахад бага байгаа бөгөөд тэр дундаа баруун болон хангайн бүсийн ажиллагчдын цалин ойролцоогоор 20-25 хувиар бага байна. Төвийн бүсийн цалингийн ялгаа 2021 онд 7.9 хувь буюу өмнөх оноос 4.1 хувиар, 2023 онд 4.3 хувь болж тус тус буурсан. Харин төвийн бүсийн ялгаа 2021 онд буурч 2023 онд 12 хувь байгаа нь 3.1 хувиар өссөн дүн байна.

### Хөдөлмөргийн зардлын шинжилгээ

Цалин хөлс нь ажиллагчид болон тэдгээрийн өрхөд орлого, харин ажил олгогч байгууллагын хувьд үйл ажиллагаа эрхлэх, бараа бүтээгдэхүүн боловсруулах ажиллагаанд хөдөлмөр ашигласны зардал болдог. Судалгааны үр дүнгээр байгууллагын хөдөлмөр эрхлэлт, үйл ажиллагаанд гарч буй нийт зардлын 86,8 хувийг ажиллагчдын цалин хөлсний зардал бүрдүүлж байгаа үр дүн гарсан. нэрлэсэн болон бодит хөдөлмөрийн эрхлэлтийн зардлыг дараах үзүүлэлтүүдээр тооцох боломжтой байна. Үүнд, үндсэн цалин, нэмэгдэл, нэмэгдэл хөлс, шагнал урамшуулал, олговор болон нийгмийн хамгааллын, сургалтын болон бусад зардлууд орсон.

Хүснэгт 10. Нэг ажиллагчид ногдох НЭРЛЭСЭН хөдөлмөрийн зардал, мян.төг

| | Нэрлэсэн хөдөлмөрийн зардал, мянган төгрөг | | | Өөрчлөлт, хувиар (өмнөх жилээс) | | | Ердийн цагийн горимоор 1 сард ажилласан хоног |
|---|---|---|---|---|---|---|---|
| | Сард | Өдөрт | Цагт | Сард | Өдөрт | Цагт | |
| **2019** | 1,080.2 | 49.8 | 6.2 | 34.7 | 31.3 | 28.5 | 22 |
| **2021** | 1,158.9 | 57.3 | 7.2 | 7.3 | 15.1 | 16.7 | 21 |
| **2023** | 1,912.3 | 93.9 | 18.5 | 65.0 | 63.8 | 157.0 | 22 |

Судалгааны үр дүнгээр нэрлэсэн хөдөлмөрийн дундаж зардал 2019-2023 оны хооронд өссөн үзүүлэлттэй байна. ААНБ-аас нэг ажиллагчид 1 сард ногдох хөдөлмөр эрхлэлтийн зардал 2021 онд 7.3 хувиар өссөн бол өдрийн зардал 15.1 хувиар, цагийн зардал 16.7 хувиар харилцан адилгүй өссөн байсан. Харин 2023 онд мөн адил цагийн хөдөлмөр эрхлэлтийн зардал сарын болон өдрийн зардлаас 2 дахин илүү өсөлттэй байна.

Хүснэгт 11. Нэг ажиллагчид ногдох БОДИТ хөдөлмөрийн зардал, 2015 оны үнээр, мян.төг

| | Бодит хөдөлмөрийн зардал, 2015 оны мянган төгрөг | | | Өөрчлөлт, хувиар (өмнөх жилээс) | | | Ердийн цагийн горимоор 1 сард ажилласан хоног |
|---|---|---|---|---|---|---|---|
| | Сард | Өдөрт | Цагт | Сард | Өдөрт | Цагт | |
| **2019** | 1013.7 | 46.7 | 5.8 | - | - | - | 22 |
| **2021** | 1091.5 | 54.0 | 6.8 | 7.7 | 15.5 | 17.1 | 21 |
| **2023** | 1790.4 | 88.0 | 17.4 | 64.0 | 62.9 | 156.5 | 22 |

Харин бодит хөдөлмөрийн зардлын хувьд 2021 онд сарын дундаж хөдөлмөрийн зардал 2019 оныхоос 7.7 хувиар өссөн бол өдрийн болон цагийн зардал 15.5, 17.1 хувиар тус тус өссөн, 2023 онд сарын зардал 64 хувиар өдрийн зардал 62.9 хувиар нэмэгдсэн харагдаж байна.

### Цалингийн хүйсээрх ялгаа

Судалгааны үр дүнгээс цалингийн харьцааг хүйсээр тооцон өмнөх шинжилгээний ажилд хамрагдсан гурван оны дүнгээр харьцуулан нийтэд нь харвал 2015 онд ялгаа хамгийн бага буюу эмэгтэй ажиллагчдын цалин эрэгтэй ажиллагчдын цалингаас 2.5 хувиар бага өөрөөр хэлбэл эрэгтэйчүүдийн нийт цалингийн 97.5 хувьтай тэнцэх хэмжээний цалинг эмэгтэйчүүд авч байсан. Харин 2019 онд эрэгтэй эмэгтэй ажиллагчдын цалингийн харьцаа 94.2 хувьтай цалингийн ялгаа нь 6.01 хувь болж хоёр жилийн өмнөхтэй харьцуулахад 1.5 хувиар буурсан байна. Гэвч 2023 онд цалингийн харьцаа 0.91 буюу эрэгтэй ажиллагчдын дундаж цалингийн 91 хувийг эмэгтэйчүүд авч цалингийн ялгаа нь 9.5 хувь болж нэмэгдсэн байна.

Зураг 41. Эрэгэй, эмэгтэй ажиллагсдын цалингийн ялгаа




### Цалингийн ялгааны задаргаа

Цалингийн зөрүүг тайлбарлах үүднээс Oaxaca-Blinder (Oaxaca (1973), Blinder (1973) нарын задаргаа хийдэг уламжлалт аргачлалыг ашиглан шинжилгээ хийж цалингийн засварласан харьцаагаар тайлбарласан. Онолын тайлбарыг товч дурдахад, цалингийн засварласан харьцаа гэдэг нь хүмүүн капитал болон өргөтгөсөн загвараас тооцсон цалингийн харьцаа юм.

Хүмүүн капитал болон өргөтгөсөн загварын аль алинаас нь дээрх аргаар тооцсон эрэгтэй, эмэгтэй ажиллагчдын цалингийн засварлаагүй болон засварласан харьцааг дараах

зурагт харуулав. Засварлаагүй цалингийн харьцаа 2019 онд 93.7 хувь, 2021 онд бага зэрэг өсөж 93.8 хувь болсон бол 2023 онд буурч 90.6 хувь болсон байна. Засварласан цалингийн харьцаа засварлаагүй харьцаанаас гурван оны турш бага байх хандлагатай байна. Хүмүүн капиталтай загвараар үнэлэгдсэн цалингийн харьцаа 2019 онд 88.3 хувь, 2021 онд 90.0 хувь байсан бол 2023 онд 87.7 хувь болж буурсан байна. Өөрөөр хэлбэл, хүмүүн капиталын загвараас үнэлсэн эмэгтэй, эрэгтэй ажиллагсдын цалингийн (хүмүүн капиталаар) тайлбарлагдахгүй ялгаа нь 2019 онд 11.7 хувь, 2021 онд 10.0 хувь, 2023 онд 12.3 хувь байна.

Зураг 42. Засварлаагүй болон засварласан цалингийн харьцаа




Дээрх үр дүнгээс үзэхэд хүмүүн капиталын загвараас тооцсон цалингийн ялгаа нь засварлаагүй ялгаанаас их байна. Энэ нь эмэгтэй ажиллагчдын хүмүүн капитал эрэгтэйчүүдийнхээс их байгааг харуулна. Судалгаанд хамрагдсан ажиллагчдын шинж байдлыг харахад хүмүүн капиталын үзүүлэлтүүдээр эмэгтэйчүүд эрчүүдээс илүү байсан бол уг үр дүнг тус загвар баталж гаргасан юм.

Хүснэгтийн А хэсэгт хүмүүн капиталын загвараас үнэлэгдсэн үр дүнг харуулав. Эмэгтэй ажиллагчид эрэгтэйчүүдээс ажлын туршлага болон боловсролын үзүүлэлтүүдээр илүү байгаа нь цалингийн ялгааг бууруулж байна. Тухайлбал, цалингийн ялгааг эмэгтэй ажиллагсдын боловсрол  3.2-3.8 пунктээр, ажлын туршлага 0.2-1.5 пунктээр бууруулж байна. Хүснэгтийн Б хэсэгт өргөтгөсөн загвараас үнэлэгдсэн хувь нэмрийг харуулж байна. Боловсрол болон туршлагын нөлөө хүмүүн капиталын загварынхтай ойролцоо байна. Энэ нь эдгээр хүчин зүйлсийн нөлөө эдийн засгийн үйл ажиллагааны салбар, ажил мэргэжил, хамтын гэрээ болон төрийн секторын хүрээн дотор бий болдог гэдгийг харуулж байна. 2019 онд эдийн засгийн үйл ажиллагааны салбар болон ажил мэргэжил нийлээд цалингийн хүйсээр ялгааг 5 пункт буюу 16.4 хувиар  өсгөсөн. Эдийн засгийн үйл ажиллагааны салбар болон ажил мэргэжил нийлээд 2021 онд 5.7 пункт буюу 16.8 хувиар, 2023 онд 4.4 пункт буюу 19.2 хувиар цалингийн ялгааг тус тус өсгөсөн байна. Эндээс үзэхэд, салбар болон ажил мэргэжлийн хүчин зүйлс цалингийн хүйсээр ялгаа бий болгож байгаа хамгийн гол хувьсагчид байна.

## Хүснэгт 12. Цалингийн ялгааны задаргаа

| Хувьсагчид | 2019 Лог утга | 2019 Хүйсийн ялгааны тайлбарлагдах % | 2021 Лог утга | 2021 Хүйсийн ялгааны тайлбарлагдах % | 2023 Лог утга | 2023 Хүйсийн ялгааны тайлбарлагдах % |
|---|---|---|---|---|---|---|
| **А. Хүмүүн капиталын загвар** | | | | | | |
| **Туршлагын хувьсагчид** | -0.0193 | -6.3 | -0.0146 | -4.3 | -0.0026 | -1.1 |
| **Боловсролын хувьсагчид** | -0.0523 | -17.1 | -0.0379 | -11.1 | -0.0320 | -14.0 |
| **Бүсийн хувьсагчид** | 0.0130 | 4.2 | 0.0123 | 3.6 | 0.0035 | 1.5 |
| **Нийт тайлбарлагдах** | -0.0586 | -19.2 | -0.0403 | -11.8 | -0.0312 | -13.6 |
| **Нийт тайлбарлагдахгүй** | 0.3643 | 119.2 | 0.3810 | 111.8 | 0.2602 | 113.6 |
| **Нийт цалингийн ялгаа** | 0.3057 | 100 | 0.3406 | 100 | 0.2291 | 100 |
| | | | | | | |
| **Б. Өргөтгөсөн загвар** | | | | | | |
| **Туршлагын хувьсагчид** | -0.0162 | -5.3 | -0.0133 | -3.9 | -0.0019 | -0.8 |
| **Боловсролын хувьсагчид** | -0.0423 | -13.8 | -0.0361 | -10.6 | -0.0306 | -13.4 |
| **Бүсийн хувьсагчид** | 0.0157 | 5.1 | 0.0138 | 4.1 | 0.0056 | 2.5 |
| **Төр, хамтын гэрээ** | -0.0210 | -6.9 | -0.0242 | -7.1 | 0.0060 | 2.6 |
| **Ажил мэргэжлийн хувьсагчид** | -0.0184 | -6.0 | -0.0207 | -6.1 | 0.0102 | 4.5 |
| **Салбарын хувьсагчид** | 0.0686 | 22.4 | 0.0781 | 22.9 | 0.0338 | 14.8 |
| **Нийт тайлбарлагдах** | -0.0135 | -4.4 | -0.0024 | -0.7 | 0.0233 | 10.2 |
| **Нийт тайлбарлагдахгүй** | 0.3192 | 104.4 | 0.3430 | 100.7 | 0.2058 | 89.8 |
| **Нийт цалингийн ялгаа** | 0.3057 | 100 | 0.3406 | 100 | 0.2291 | 100 |

## ОЙЛГОЛТ, ТОДОРХОЙЛОЛТ

Хөдөлмөрийн насны хүн ам гэж 15, түүнээс дээш насны хүн амыг хэлнэ. Хөдөлмөрийн насны хүн амыг ажиллах хүч болон ажиллах хүчнээс гадуурх хүн ам гэж ангилна.

Ажиллах хүч гэж тухайн хугацаанд зөвхөн хөдөлмөр эрхлэлтийн ажлын хэлбэрийн хүрээнд, цалин хөлс, орлого олох зорилгоор бусдын хэрэглээнд зориулан бүтээгдэхүүн үйлдвэрлэх, үйлчилгээ үзүүлэхэд хүч хөдөлмөрөө нийлүүлж байгаа ажиллагчид болон нийлүүлэхэд бэлэн байгаа ажилгүй хүн юм.

Ажиллах хүчнээс гадуурх хүн ам гэж сургуульд суралцаж байгаа, гэрийн ажилтай, өндөр настан, өндөр насны тэтгэвэр тогтоолгосон, хөгжлийн бэрхшээлтэй болон ажил хайх итгэл алдарсан зэрэг шалтгаанаар тухайн хугацаанд ажиллах хүчинд хамаарахгүй хөдөлмөрийн насны хүн амыг ойлгоно. Ажиллах хүчнээс гадуурх хүн амаас боломжит ажиллах хүчийг тодорхойлно. Мөн ажиллах хүч болон боломжит ажиллах хүч хоёрын нийлбэрээр өргөтгөсөн ажиллах хүч илэрхийлэгдэнэ.

Хөдөлмөрийн дутуу ашиглалт гэж хөдөлмөрийн нийлүүлэлт болон эрэлтийн зөрүү буюу хөдөлмөрийн насны хүн амын хөдөлмөр эрхлэлтийн хэрэгцээ хангагдахгүй байхыг ойлгоно.

Цаг хугацаанаас хамаарсан бүрэн бус хөдөлмөр эрхлэгч гэж тухайн хугацаанд хөдөлмөр эрхэлж буй ажиллагчийн бүх ажлынх нь ажлын цаг нь үндэсний хууль тогтоомжид заасан босго цагаас бага бөгөөд өөр ажил хийх хүсэлтэй, нэмэлт цагаар ажиллахад бэлэн байгаа хүнийг ойлгоно. Босго цаг гэдгийг Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хуульд заасны дагуу 7 хоногийн ажлын 5 өдрийн 40 цагаар авч үзнэ.

Ажилгүй хүн гэж сүүлийн 7 хоногт хөдөлмөр эрхлээгүй, хөдөлмөр эрхлэх зорилгоор ажил хайж байгаа болон ажил хийхэд бэлэн байгаа хөдөлмөрийн насны хүн юм.

Боломжит ажиллах хүч гэж цалин хөлс, орлого олох зорилгоор хөдөлмөр эрхлэхийг сонирхож байгаа боловч тодорхой нөхцөл байдлын улмаас ажил хайх оролдлого нь хязгаарлагдсан эсвэл шууд ажил хийх боломжгүй байгаа, тухайн хугацаанд хөдөлмөр эрхлээгүй хүн юм.

Ажиллах хүчний оролцооны түвшин: Ажиллах хүчний тоог хөдөлмөрийн насны хүн амын тоонд харьцуулж тооцно.

$$\text{АХОТ} = \frac{\text{Ажиллах хүч}}{\text{Хөдөлмөрийн насны хүн ам}} * 100\%$$

Хөдөлмөр эрхлэлтийн түвшин: Ажиллагчдын тоог хөдөлмөрийн насны хүн амын тоонд харьцуулж тооцно.

$$\text{ХЭТ} = \frac{\text{Ажиллагчдын тоо}}{\text{Хөдөлмөрийн насны хүн ам}} * 100\%$$

Даатгуулагч гэж хууль болон гэрээний үндсэн дээр нийгмийн даатгалын санд нийгмийн даатгалын шимтгэл төлж даатгуулсан, нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж, төлбөр авах эрх бүхий этгээдийг хэлнэ.

Нийгмийн даатгалын шимтгэл гэж нийгмийн даатгалд даатгуулах зорилгоор иргэн болон төр, ажил олгогчоос нийгмийн даатгалын санд хуульд заасан хувь хэмжээгээр урьдчилан төлөх төлбөрийг хэлнэ.

Ажилгүйдлийн тэтгэмж гэж ажилгүй болохоосоо өмнө ажилгүйдлийн даатгалын шимтгэлийг хуульд заасан болзол, журмын дагуу төлсөн даатгуулагч ажилгүй болсон бол түүнд нийгмийн даатгалын сангаас олгох мөнгөн хөрөнгийг хэлнэ.

Дундаж цалин гэж тайлант хугацаанд цалин, хөлс авсан ажиллагчдын тоогоор жигнэсэн нийт цалин хөлс болон тайлант хугацаанд цалин хөлс авсан ажиллагчдын тооны харьцаа юм.

Нэрлэсэн цалин гэдэг нь тодорхой хугацаанд хийсэн хөдөлмөрийнхөө төлөө авч буй мөнгөн төлбөрийн дүн юм.

Ажил хайгч иргэн гэж ажилгүй эсхүл ажилтай боловч ажлын нөхцөлөө сайжруулах, нэмэлт орлого олох зорилгоор ажил хайж байгаа иргэнийг ойлгоно.

Бүртгэлтэй ажилгүй иргэн гэж хөдөлмөрлөх насны, хөдөлмөр эрхлэх чадвартай, цалин хөлстэй ажил болон хувиараа хөдөлмөр эрхэлдэггүй, тухайн үед ажиллахад бэлэн, цалин хөлстэй ажил идэвхтэй хайж байгаа хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэс, хөдөлмөрийн хувийн биржид бүртгүүлсэн ажилгүй иргэдийг хамруулна.

Байнгын ажлын байр гэж ажил олгогчийн заасан ажлын байранд, тогтоосон горимын дагуу түүнээс олгосон хөдөлмөрийн багаж хэрэгслээр, ажил олгогч, эсхүл түүний төлөөлөгчийн удирдлагын дор баталсан норм, үнэлгээ, сүлжээгээр цалин хөлс авч, ажлын өдөр, ээлжийн давтамжтайгаар гүйцэтгэх ажил үүргийг;

Байнгын ажилтан нь байнгын ажлын байранд ажиллах албан ёсны гэрээтэй бөгөөд ажил олгогч нь татвар болон нийгмийн даатгалын шимтгэлийг хариуцан төлдөг, хөдөлмөрийн харилцаа нь хөдөлмөрийн тухай болон төрийн албаны тухай хууль тогтоомжоор зохицуулагддаг иргэнийг;

Албан бус ажил олгогч гэж тогтмол хугацаанд нэг буюу түүнээс дээш хүнийг цалин хөлстэй ажиллагчаар ажиллуулдаг хувиараа хөдөлмөр эрхлэгч. Цаашид энэ ангиллын албан бус хөдөлмөр эрхлэгчдийг ажил олгогч гэж нэрийднэ.

Ажиллагч албан бус хөдөлмөр эрхлэгч гэж хөдөлмөрийн харилцаа нь хууль эрх зүйн хүрээнд бүрэн зохицуулагдаагүй нөхцөлд ажиллаж буй цалин хөлстэй ажиллагч. Цаашид ажилтан энэ ангиллын албан бус хөдөлмөр эрхлэгчдийг ажилтан гэж нэрийднэ.

## АШИГЛАСАН МАТЕРИАЛ


1. Монгол Улсын “Хөдөлмөрийн тухай” хууль, 2021 он
2. “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай” хууль, 2011 он
3. Хөдөлмөр эрхлэлтийн статистикийн үзүүлэлтийг тооцох аргачлал, Үндэсний статистикийн хороо, 2019 он
4. Ажиллах хүчний судалгааны тайлан, Үндэсний статистикийн хороо, 2024 оны I улирал
5. Нийгмийн даатгалын хамрагдалт, тэтгэвэр, тэтгэмж авагчдын сарын мэдээ, Нийгмийн даатгалын ерөнхий газар
6. Ажил хайгч иргэний хөдөлгөөний сарын мэдээ, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар
7. Бүртгэлтэй ажилгүй иргэний хөдөлгөөний сарын мэдээ, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар
8. Ажлын байрны захиалга, ажилд зуучлагдсан иргэдийн мэдээ, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар
9. Хөдөлмөрийн зах зээлийн тойм 2024 оны IV улирал
10. Цалингийн бүтцийн судалгаанд хийсэн шинжилгээний ажил-2025


## АШИГЛАСАН ЦАХИМ ХУУДАС


1. www.legalinfo.mn
2. www.1212.mn
3. www.mlsp.gov.mn/sp-dictionary
4. www.ndaatgal.mn/v1/
5. www.hudulmur-halamj.gov.mn